



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

### Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүрэг, бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын а заалт, Монгол Улсын Их Хурлын 2009 оны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, Концессын хууль, концессын зүйлийг хэрэгжүүлэх, өмчийн эзэмшилт, ашиглалт, хяналт, захиран зарцуулалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүрэгт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрмийг хавсралтаар, бүтцийг дор дурдсанаар баталсугай.

- а. Өмчийн төлөөлөл, хувьчлалын хэлтэс
- б. Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс
- в. Захиргаа удирдлагын хэлтэс /ашиглалтын захиргаатай/
- г. Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын хэлтэс
- д. Өмчийн хяналт шалгалт, хууль зүйн хэлтэс

Хоёр. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын удирдлагын орон тоог дарга, орлогч 2-той байхаар, төрийн захиргааны албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 48, үйлчилгээний албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 37 байхаар тус тус баталсугай.

Гурав. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин, нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, хөдөлмөрийн дотоод журмыг дүрэмд нийцүүлэн шинэчлэн баталж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ц.Баасанжав/-т даалгасугай.

Дөрөв. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын чиг үүрэгт өөрчлөлт орж, бүтэц зохион байгуулалт, орон тоо шинэчлэгдэж байгаатай холбогдуулан тус газарт шаардагдах зардлыг 2011 оны нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т үүрэг болгосугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны "Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын тухай" 14 дүгээр захирамжийн хавсралтын 18-д заасан Өмчийн харилцааны газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоосон хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г.МӨНХБАЯР

Нийслэлийн Засаг даргын 2011 оны  
5 дугаар сарын 07-ны өдрийн  
456 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
АГЕНТЛАГ ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь /цаашид "газар" гэх/  
Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

-Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын өмнө өмчийн  
болон төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын асуудлаар зөвлөхийн үүрэг  
хүлээх;

-Нийслэлийн өмч, өмчийн харилцаа, төр, хувийн хэвшлийн түншлэл,  
концессын асуудалтай холбогдсон нэгдсэн бодлого, шийдвэрийг боловсруулах,  
түүний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

-Дүүрэг болон нийслэлийн өмчийн хуулийн этгээдийг өмчийн талаар нэгдсэн  
удирдлагаар хангах;

-Нийслэл хотыг хөгжүүлэх эдийн засаг, нийгмийн зорилтуудыг биелүүлэх;

-Нийслэлийн өмчийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, үйлдвэрлэл,  
үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар салбар хоорондын  
зохицуулалтаар хангаж, удирдах;

-Концессын тухай хууль, төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар  
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас баримтлах бодлогын  
хүрээнд нийслэлд хэрэгжүүлэх "Орон нутгийн өмчийн концессын зүйлийн  
жагсаалт"-ыг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх;

-Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах талаар гарсан үндсэн чиглэл,  
хөтөлбөрийн дагуу хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

-Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь Нийслэлийн Засаг даргын  
хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2.Газар нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг  
захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Иргэний хууль,  
Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,



Концессын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрүүд, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3.Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга батална.

1.4.Газар нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад ажлаа тайлагнана.

1.5.Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.6.Газар нь өөрийн бэлэгдлийн тэмдэгтэй байж болно.

1.7.Өөрийн эрх мэдлийн хүрээнд өмч, өмчийн харилцаа, концессын талаар гаргасан шийдвэрийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, хуулийн этгээдүүд салбарын харьяалал, өмчийн хэлбэрийг үл харгалзан заавал дагаж мөрдүүлнэ.

**Хоёр. Зохион байгуулалт, удирдлага**

2.1.Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө.

2.2.Газар нь хэлтэс, ашиглалтын захиргаатай байна.

2.3.Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

2.4.Газар нь өдөр тутмын үйл ажиллагаагаа дотоод журмыг мөрдөн жил, сарын ажлын төлөвлөгөө, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний дагуу явуулна.

2.5.Газар нь эд хөрөнгийн эрхийн байдлаар төсөвт байгууллага байх ба төсвөөс санхүүжих зарчмаар ажиллана.

2.6.Газрын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлж, тушаал, журам, заавар, бусад шийдвэрийг гаргаж, байгууллагын үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

2.7.Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж чөлөөлөх бөгөөд дэд дарга, хэлтсийн дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана. Дэд даргыг томилж чөлөөлөхдөө Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөнө.

2.8.Газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, газрын дотоод журмын дагуу, батлагдсан төсөвт багтаан ажилтнуудын шагнал, урамшуулал, цалингийн шатлалыг тогтооно.

2.9.Газрын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн зарим ажлыг хуульд нийцүүлэн гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.10.Газрын даргын эзгүйд дэд даргын аль нэг төлөөлж бусад байгууллагатай харьцаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.

2.11.Газрын дарга нь хуульд заасан бусад эрхийг хэрэгжүүлж, үүрэг хүлээнэ.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

3.1.Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1.1.Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3.1.2 Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнан ажиллах.

3.1.3 Газрын үйл ажиллагаа нь нийслэлийн өмчит хуулийн этгээдүүд болон дүүргийн өмчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах, эрх зүйн орчныг шинэчлэх, өмч хувьчлалын үйл ажиллагааг төсөвлөх, төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зэргээр өмчийн харилцааг зохицуулан, төлөөллийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

3.2 Үүрэг

3.2.1 Орон нутгийн өмч, төр, хувийн хэвшлийн түншлэл концессын талаар гарсан бодлого шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих.

3.2.2 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, шинээр хамтарсан аж ахуйн нэгж байгуулах санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх.

3.2.3 Нийслэлийн өмчид хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтаа татан авах, нийслэлийн өмчийн хувьцаа, бонд зэрэг үнэт цаас гаргах, хувь хөрөнгийг худалдах, хувьчлах зэрэг асуудлаар санал боловсруулан шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.2.4 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах арга хэмжээ авах.

3.2.5 Нийслэлийн өмчийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх:

-Нийслэлийн өмчид хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө

-Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой

үйлдвэрийн газрууд

- Нийслэлийн өмчит төсөвт байгууллагууд
- Нийслэлийн өөрийн өмчид бүртгэлтэй эд хөрөнгө
- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, хандив, төсөл хөтөлбөр, төр хувийн хэвшлийн түншлэл, концесс зээлийн шугамаар бий болж байгаа хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжуудийг бүртгэн хяналт тавих.

3.2.6 Нийслэлийн өмч, түүний нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, автоматчилагдсан мэдээлэл зүйн системийн эзэмшигч нь байна.

3.2.7 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөний талаар шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангах.

3.2.8 Нийслэлийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, хөтөлбөр, тухайн санхүүгийн хугацааны төсвийн төслийг боловсруулахад оролцож, нийслэлийн удирдлагад дараах асуудлуудаар санал, шийдвэрийн төслийг бэлтгэн танилцуулна:

- Нийслэлийн өмчөөс төсөвт орох орлогын төлөвлөгөөний төсөл
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах хөтөлбөр
- Нийслэлийн өмчид хөрөнгө шинээр авах, шинэ өмч бий болгох хөтөлбөр
- Нийслэлийн өмчид хийгдэх техник, технологийн шинэчлэл, их засварын төлөвлөгөөний төсөл
- Нийслэлд хэрэгжих төр хувийн хэвшлийн түншлэл, концессын ажлуудын эргэн төлөлтөд шаардагдах төсвийн төлөвлөгөө төсөл

3.2.9 Нийслэлийн өмчийн барилга байгууламжинд өргөтгөл шинэчлэл, их засвар, техник технологийн өөрчлөлттэй холбогдсон хөрөнгө оруулалт хийх асуудлаар холбогдох байгууллагуудтай зөвшилцөн санал боловсруулж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулан шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтэнд хяналт тавих.

3.2.10 Нийслэлийн өмчид хийгдэх хөрөнгө оруулалтын ажлыг хийх, үйлчилгээ үзүүлэх, захиалга гүйцэтгэхэд холбогдох хуулийн хүрээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэнэ.

3.2.11 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэж, холбогдох байгууллагуудад тайлагнах.

3.2.12 Нийслэлийн өмчлөлд байгаа үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулагч хуулийн этгээдүүдээс оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, баталгаажуулах, хяналт тавих.

3.2.13 Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, гуравдагч этгээдийн өмчлөлд байгаа өмч хөрөнгийн үнэлгээг хийх, шаардлагатай тохиолдолд үнэлгээний тайланд экспертиз хийлгэх

3.2.14 Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн даатгалын асуудлыг зохион байгуулах.

3.2.15 Улсын Их Хурал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

шийдвэрээр нийслэлийн өмчид шилжин ирж байгаа хөрөнгийг хүлээн авч бүртгэх, эзэмшигчдэд хүлээлгэн өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих.

3.2.16 Нийслэлийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлс, нормативыг холбогдох эрх бүхий байгууллагын санал дүгнэлтийн үндсэн дээр тогтоож өгөх.

3.2.17 Нийслэлийн өмчийг хуулийн этгээдэд түрээсийн гэрээгээр эзэмшүүлэн төлбөр тооцоо хийх, эзэмшилт ашиглалтанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулж гүйцэтгэх.

3.2.18 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг лизингээр шилжүүлэх талаар асуудал боловсруулан шийдвэрлүүлж хэрэгжүүлэх, түүний ашиглалтын орох орлогыг хянах.

3.2.19.Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд нийслэлийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах.

3.2.20. Нийслэлийн өмчит төсвийн байгууллагуудын удирдлагуудтай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулан хэрэгжилтэнд хяналт тавих.

3.2.21.Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудтай контракт гэрээ байгуулах, тухайн салбарын удирдах байгууллагуудтай хамтран түүний хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай тохиолдолд захирлыг томилох, чөлөөлөх саналыг боловсруулж Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх.

3.2.22 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагаар хяналт, мониторинг хийлгэх.

3.2.23 Нийслэлийн өмчид ногдох ногдол ашиг, түрээсийн төлбөр, өмч хувьчлалаар олсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн хотын хөрөнгө оруулалтын сангийн төлөвлөгдсөн эх үүсвэрийг бүрдүүлэх.

3.2.24 Нийслэлийн өмчит байгууллагуудын авлага, өр төлбөрийг барагдуулах асуудлыг шийдвэрлэхэд оролцож, авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийх.

3.2.25 Нийслэлийн өмчийн болон нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн ногдол ашиг болон түрээсийн орлогын төвлөрүүлэлтийн байдалд үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

3.2.26 Нийслэлийн өмчит байгууллагуудын эдийн засгийн үр ашиг буурах, алдагдалд орох, өр төлбөрийн хэмжээ нэмэгдэхээс сэргийлэх арга хэмжээ авах.

3.2.27 Нийслэлийн өмчийг үрэгдүүлсэн, нийслэлийн өмчит хуулийн этгээд нь гэрээнд заасан үүргийг хангалтгүй биелүүлснээс үүссэн өмч хөрөнгийн холбогдолтой маргааныг шийдвэрлүүлэхэд нэхэмжлэгчээр оролцох.

3.2.28 Менежментийн болон удирдлагын гэрээ, хязгаартай дуудлагын худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар нийслэлийн өмчийг хувьчлан авсан этгээдийн гэрээ, концессын гэрээний биелэлтэнд тухайн салбарын удирдах байгууллагуудтай хамтран хяналт тавих. Гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд хууль болон гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах.

3.2.29 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтанд эрх хэмжээний хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран шалгалт хийх, аудитын шалгалт оруулах шийдвэр гаргуулах, түүнийг зохион байгуулах.

3.2.30 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү болон аж ахуйн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит оруулах ажлыг зохион байгуулах.

3.2.31 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувь нийлүүлэгчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах нийслэлийн өмчийн төлөөлөгчийг томилж, чөлөөлөх асуудлаар Нийслэлийн Засаг даргад санал оруулан шийдвэрлүүлэх.

3.2.32 Өмчийн төлөөлөгчийн төлөөлөл хэрэгжүүлэх эрх хэмжээ, ажиллах журам, зааврыг батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавих.

3.2.33 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлийн өмнө тулгамдсан дэд бүтэц болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх хүрээ хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг уялдуулан зохион байгуулах.

3.2.34 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар бодлого, шийдвэрийн хувилбар боловсруулах концессын зүйлийн талаар судалгаа хийх, арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалт боловсруулж батлуулах.

3.2.35 Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулах.

3.2.36 Концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарлах, түүнийг зохион байгуулах, концессын гэрээ болон түүнтэй холбоотой бусад гэрээг байгуулах бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ хийх, дүгнэх.

3.2.37 Нийслэл хотын хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрийг боловсруулах, шинээр өмч бий болгох ажлыг зохион байгуулж шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх.

3.2.38 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийслэлийн хувийг холбогдох журмын дагуу хувьчлах талаар санал боловсруулан холбогдох байгууллагуудад өргөн барих. Хувьчлах санал болон орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг боловсруулахдаа тухайн салбарын удирдах байгууллагуудаас санал авах.

3.2.39 Газрын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, иргэдийг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.



3.2.40 Нийслэлд шинээр өмч бүрдүүлэх, өмчийн үр ашгийг дээшлүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэл, концессын зүйлийг хэрэгжүүлэх чиглэлүүдээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.2.41 Нийслэлийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах.

3.2.42 Нийслэлийн өмчит болон төсөвт байгууллагуудын эзэмшил газрын хадгалалт, хамгаалалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ашиглаж байгаад хяналт тавих.

### 3.3 Эрх

3.3.1 Газар нь чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг бүтээгдэхүүний хэлбэрээр нийлүүлнэ.

3.3.2 Мөрдөгдөж байгаа хууль, журмын дагуу байгууллагын бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө, ажилчдын цалингийн хэмжээг тогтооно.

3.3.3 Газрын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг нийслэлийн төсөвт суулган, батлагдсан төсөв, бүтэц, орон тооны хязгаарт багтаан захиран зарцуулна.

3.3.4 Газрын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, шаардлагатай тохиолдолд албан хаагч, ажилчдад Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хуулийн дагуу хариуцлагын арга хэмжээ авна.

3.3.5 Газрын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар тушаал, шийдвэр гарган түүний хэрэгжилтэнд хяналт тавина.

3.3.6 Алслагдсан дүүрэгт өөрийн төлөөлөгчтэй байж болох бөгөөд тухайн нутаг дэвсгэрт өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих.

3.3.7 Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтын захиргаа байгуулан ажиллах.

3.3.8 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хуулийн дагуу худалдан авах бараа, ажил үйлчилгээ, их засвар, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх.

3.3.9 Нийслэлийн өмчид хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын ажлыг хийх, үйлчилгээ үзүүлэх, захиалга гүйцэтгэхэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд захиалагчийн эрхтэйгээр оролцох.

3.3.10 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалтын талаар шаардлагатай бичиг баримт, мэдээ судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах.

3.3.11 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс санхүү эдийн засгийн үйл ажиллагааны талаарх бичиг баримт, үнэн зөв мэдээллийг шаардан авах.

3.3.12 Нийслэлд хэрэгжүүлэх орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын төсөл, Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах хөтөлбөрийн төсөл, хувьчлалын арга хэлбэрийг тогтоох тухай саналаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад өргөн мэдүүлэх.

3.3.13 Нийслэлийн өмчийг түрээсээр эзэмшигчтэй түрээсийн гэрээ байгуулах.

3.3.14 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн удирдлага гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд арга хэмжээ авах, албан тушаалаас нь өөрчлөх санал оруулах.

3.3.15 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдах албан тушаалтныг томилоход санал оруулах.

3.3.16. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг барьцаанд тавих талаар эрх бүхий байгууллагад санал оруулах, гэрээ хэлцэл хийх.

3.3.17. Нийслэлийн өмчийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийг даатгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3.3.18. Нийслэлийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг бүртгэн баталгаажуулах ажлыг зохион байгуулах.

3.3.19. Дүүргийг өмчийн нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих, шаардлагатай мэдээ мэдээллийг гаргуулан авах.

3.3.20. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн болон концессын гэрээтэй байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийх.

3.3.21. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын бүтэц зохион байгуулалт, өөрчлөх, татан буулгах, тэдгээрийг шинээр байгуулах, саналыг холбогдох байгууллагуудад оруулах.

3.3.23. Нийслэлийн өмчийг эзэмшигч байгууллага иргэд өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар хууль тогтоомж зөрчсөн нөхцөлд эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авах.

3.3.24 Өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг хуулийн байгууллагад төлөөлж, хотын эрх ашгийг хамгаална.

3.3.25 Нийслэлийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах явцад бий болсон бичиг баримтыг холбогдох хууль, журмын хүрээнд архивлах, хадгалж, ашиглах эрхтэй.

3.3.26 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж байгуулах санал боловсруулан холбогдох шийдвэрийг гаргуулах.

3.3.27 Нийслэлийн хүн амын ая тухтай байдлыг хангах, дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах зорилгоор өмч бий болгох асуудлыг судлаж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дөрөв. Шагнал урамшил, хариуцлага

4.1. Газрын албан хаагчдыг ажлын үр дүнгээр шагнаж, урамшуулах асуудлыг холбогдох байгууллагад уламжлах.

4.2. Албан ажилдаа хайхрамжгүй /хариуцлагагүй/ хандсаны улмаас бусдын хууль ёсны эрх ашгийг нь хохироосон албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу сахилгын шийтгэл ногдуулж, хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

5.2 Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж, бүртгүүлнэ.